



**ХӨВСГӨЛ АЙМГИЙН
УЛААН-УУЛ СУМЫН ЗАСАГ ДАРГЫН
ЗАХИРАМЖ**

2024 оны 10 сарын 25 өдөр

Дугаар 1/95

Төгөл

Бүх нийтээр мод тарих үндэсний
өдрийг зохион байгуулах тухай

Монгол улсын Засаг захиргаа нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 59 дүгээр зүйлийн 59.1.1, дэх заалт, 66 дугаар зүйлийн 66.1, Байгаль орчин хамгаалах тухай хуулийн 17 дугаар зүйлийн 17.2 дахь хэсэг, Ойн тухай хуулийн 18 дугаар зүйлийн 18.2.1, 18.2.2, 18.2.4, Мод тарих үндэсний өдөр зарлах тухай Монгол Улсын ерөнхийлөгчийн 2010 оны 63 дугаар зарлигийг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1. "Тэр бум мод үндэсний хөдөлгөөн", Аймгийн Засаг даргын санаачилсан "Мод тарьж ногоон суварга босгоё" аяны хүрээнд намрын мод тарих өдрийг сумын хэмжээнд 2024 оны 10 сарын 25-ны өдөр зохион байгуулсугай.

2. "Намрын бүх нийтийн мод тарих өдөр"-ийн хүрээнд аж ахуйн нэгж байгууллагуудыг нийтийн эзэмшлийн ногоон байгууламжид мод тариулж, айл өрх, иргэдийг өргөнөөр хамруулах ажлыг зохион байгуулахыг Засаг даргын Орлогч, Байгаль орчин тогтвортой хөгжлийн бодлогын тасгийн дарга М.Отгонбаатар, багийн Засаг дарга нарт тус тус үүрэг болгосугай.

3. Намрын мод тарих ажлын хүрээнд төв суурин газрын ногоон байгууламжийг нэмэгдүүлэх ойн зурвас байгуулахад шаардагдах үржил шим хөрс, өтгө бууц, усалгаа арчилгаа, хашаа хайс, хамгаалалтын асуудлыг шийдвэрлэж хариуцан ажиллахыг Засаг даргын орлогч (М.Отгонбаатар)-т үүрэг болгосугай.

4. Зохион байгуулж буй ажилд шаардлагатай бензен шатахуун, техник хэрэгсэл бусад зүйлээр ханган ажиллахыг Засаг даргын Тамгын газрын дарга М.Батцогт, Нягтлан бодогч Т.Намжилсүрэн, Нярав Ч.Хүнбиш нарт тус тус даалгасугай.

5. Энэхүү захирамжийн хэрэгжилтэд хяналт тавьж, ажиллахыг Тамгын газрын дарга (М.Батцогт)-д үүрэг болгосугай.

ДАРГА  Н.БАТБАЯР

/ЗАХИРАМЖ/